

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

ОДОО ХУЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БАЙГАА	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.</p> <p>2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах</p> <p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.</p> <p>3 дугаар зүйл. Мэдээлэлд хяналт тавихыг хориглох</p> <p>3.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.</p> <p>3.2. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.</p> <p>4 дүгээр зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох</p> <p>Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.</p>	<p style="text-align: center;">НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл</p> <p style="text-align: center;">1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах эрх зүйн үндсийг тодорхойлж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж</p> <p>2.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,¹ энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1.“хэвлэл мэдээллийн эрх чөлөө” гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг;</p> <p>3.1.2.“мэдээ, мэдээлэл” гэж иргэдийн танин мэдэхүйд зориулсан уншиж, сонсч, харж болох аливаа өгөгдлийг;</p> <p>3.1.3.“хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэж мэдээ, мэдээллийг нийтэд түгээх зориулалтаар эрхлэн гаргадаг сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим хуудас болон хуулиар хориглоогүй бусад хэрэгслийг;</p> <p>3.1.4.“хэвлэл мэдээллийн байгууллага” гэж хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргадаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг.</p>	<p style="text-align: center;">НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл</p> <p style="text-align: center;">1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн байгууллагын ил тод байдал, хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж</p> <p>2.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> <p>2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1. Энэ хуульд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1.“хэвлэл, мэдээллийн хэрэгсэл” гэж олон нийтэд зориулж мэдээлэл тогтмол түгээдэг сонин хэвлэл, радио, телевиз, цахим хэвлэлийг;</p> <p>3.1.2.“хэвлэл мэдээллийн байгууллага” гэж мэдээлэл хайх, цуглуулах, хүлээн авах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх, түгээх зэрэг сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;</p> <p>3.1.3.“мэдээллийн эх сурвалжийг нууцлах” гэж нэрээ нууцлахыг хүссэн мэдээлэгчийг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага, түүний редакц, ажилтнууд илчлэхгүй байхыг;</p> <p>3.1.4.“хэвлэл мэдээллийн байгууллагын</p>

¹ Монгол Улсын Үндсэн хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

		редакц” гэж хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтэд түгээх мэдээллийн бодлого, агуулгыг тодорхойлж буй нэгжийг.
	<p style="text-align: center;">ХОЁРДУГААР БҮЛЭГ <u>Хэвлэл мэдээллийн эрх чөлөө</u></p> <p style="text-align: center;">4 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө</p> <p>4.1. Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, ял шийтгүүлсэн эсэхийг үл харгалзан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүн бүр эдэлнэ.</p> <p>4.2. Хуулийн хүрээнд мэдээ, мэдээллийг хайх, эрэн сурвалжлах, хүлээн авах, цуглуулах, дүн шинжилгээ хийх, өөрийн хэрэгцээнд ашиглах, эсхүл хэвлэн нийтлэх буюу бусад аргаар нийтэд түгээх замаар хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлнэ.</p> <p>4.3. Хуулиар төр, байгууллага, хувь хүний нууцад хамааруулснаас бусад тохиолдолд энэ хуулийн 4.2-т заасан мэдээ, мэдээллийн хүрээг хязгаарлахгүй.</p> <p style="text-align: center;">5 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах</p> <p>5.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дараах тохиолдолд гагцхүү хуульд заасан журмын дагуу хязгаарлаж болно:</p> <p style="margin-left: 40px;">5.1.1.онц болон дайны байдал зарласан; 5.1.2.Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд харш үйл ажиллагаа явуулсан; 5.1.3.бусдын эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах; 5.1.4.хуулиар төр, байгууллага, хувь хүний нууцад хамааруулсан мэдээ, мэдээллийг хамгаалах.</p> <p style="text-align: center;">6 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хангах</p> <p>6.1. Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан хууль гаргахыг хориглоно.</p> <p>6.2. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан тушаал, шийдвэр гаргах буюу үйлдэл, эс үйлдэл хийхийг хориглоно.</p>	<p style="text-align: center;">ХОЁРДУГААР БҮЛЭГ <u>Хэвлэл мэдээллийн чөлөөт, хараат бус байдлын баталгаа</u></p> <p style="text-align: center;">4 дүгээр зүйл. Иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хангах</p> <p>4.1. Монгол Улсын иргэн бүр үндэс, угсаа, хэл, соёл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн чиг баримжаа, ял шийтгүүлсэн байдлыг үл харгалзан үзэл бодлоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр чөлөөтэй илэрхийлэх, түгээх, хуульд заасан журмын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах, эрхлэх эрхтэй.</p> <p>4.2. Төрийн байгууллага, албан тушаалтан аливаа иргэнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлсэнтэй нь холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх, хариуцлага хүлээлгэхийг хориглоно.</p> <p style="text-align: center;">5 дугаар зүйл. Төрөөс хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах</p> <p>5.1. Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомжийг батлан мөрдөхийг хориглоно.</p> <p>5.2. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан захиргааны акт гаргах буюу үйлдэл, эс үйлдэл хийхийг хориглоно.</p> <p>5.3. Төрийн байгууллага, албан тушаалтан сэтгүүл зүйн үйл ажиллагааны явцад хэвлэл мэдээллийн байгууллагад хяналт шалгалт хийх, агуулгыг хянах /цензур/, мэдээлэл түгээхэд саад учруулах, мэдээлэл түгээсэнтэй нь холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, зогсоох, аливаа хэлбэрээр хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.</p> <p>5.4. Хуулиар нууцад хамааруулснаас бусад тохиолдолд мэдээ, мэдээллийн хүрээг хязгаарлахыг хориглоно.</p> <p>5.5. Төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээсэнтэй нь холбогдуулан иргэн, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид энэ хуульд зааснаас бусад хариуцлага</p>

		<p>хүлээлгэхийг хориглоно.</p> <p>5.6. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянах чиг үүрэгтэй байгууллага, албан тушаал бий болгох, санхүүжүүлэхийг хориглоно.</p> <p>6 дугаар зүйл. Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглох</p> <p>6.1. Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд өөрийн эзэмшилд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.</p> <p>6.2. Төрийн байгууллага зөвхөн дараах хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлж болно:</p> <p>6.2.1. хууль тогтоомж, эрх зүйн акт, түүнтэй холбоотой лавлагаа, тайлбар, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах зорилгоор эмхтгэл, товхимол, цахим хуудас гаргах;</p> <p>6.2.2. Монгол Улсын тухай мэдээллийг дэлхий дахинд түгээх, сурталчлах үйл ажиллагаа эрхэлдэг мэдээллийн хэрэгсэлтэй байж болно. Үүнтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулна.</p> <p>7 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал</p> <p>7.1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь мэдээ, мэдээлэл хайх, хүлээн авах, шалгах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх, хадгалах, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд хараат бусаар, чөлөөтэй эрхэлнэ.</p> <p>7.2. Хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох, хэвлэл мэдээллийн байгууллагыг татан буулгахыг хориглоно.</p> <p>7.3. Хууль бусаар мэдээлэл олж авснаас бусад тохиолдолд тухайн мэдээлэл нь бусдад гэм хор учруулсан гэх үндэслэлээр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд хариуцлага хүлээлгэхийг хориглоно.</p> <p>8 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцийн бие даасан, хараат бус байдал</p> <p>8.1. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч нарын ашиг сонирхлоос хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулна.</p>
--	--	--

		<p>8.2. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч нь редакцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.</p> <p>8.3. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцийн эрхлэгч нь үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчтэй хараат бус байдлыг хангах талаар гэрээ байгуулж, байгууллагын ёс зүйн дүрэм, дотоод журамдаа тусгах үүрэг хүлээнэ.</p> <p>8.4. Нийтлэл, нэвтрүүлгийн ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад нөлөөлөхийг хориглоно.</p>
	<p style="text-align: center;">ГУРАВДУГААР БҮЛЭГ <u>Хэвлэл мэдээллийн байгууллага</u></p> <p style="text-align: center;">7 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны баталгаа</p> <p>7.1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах мэдээ, мэдээллийг хайх, хүлээн авах, шалгах, боловсруулах, эвлүүлэх, нийтлэх, нэвтрүүлэх, хадгалах, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд хараат бус, чөлөөтэй эрхэлнэ.</p> <p>7.2. Хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаагаа төрөөс хараат бус явуулна. Төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар олгогдсон бүрэн эрхээсээ гадуур аливаа хэлбэрээр хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.</p> <p style="text-align: center;">8 дугаар зүйл. Мэдээллийн эх сурвалжийг нууцлах</p> <p>8.1. Хэвлэл мэдээллийн байгууллага болон түүний редакци, сэтгүүлч, сурвалжлагч нар энэ хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээ, мэдээллийнхээ эх сурвалжийг нууцлах эрхтэй.</p> <p>8.2. Дараах тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд зөвхөн прокурорын зөвшөөрлөөр, эсхүл шүүхийн шийдвэрээр мэдээ, мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхийг хязгаарлаж болно:</p> <p>8.2.1. тухайн мэдээ, мэдээллийг үнэн бодитой эсэхийг өөр аргаар шалгаж тогтоох боломжгүй болсон;</p> <p>8.2.2. үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд ноцтой хохирол учрах, хүний амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн гэж үзэх үндэслэл байгаа</p>	<p style="text-align: center;">ГУРАВДУГААР БҮЛЭГ <u>Мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах</u></p> <p style="text-align: center;">9 дүгээр зүйл. Зохиогч, мэдээллийн эх сурвалжийн нууцлал</p> <p>9.1. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч дараах тохиолдолд олж авсан мэдээллийнхээ эх сурвалжийг илчлэхгүй байх үүрэгтэй:</p> <p>9.1.1. мэдээлэл авсан тухайгаа задруулахгүй байхаар мэдээлэгчтэй харилцан тохиролцсон;</p> <p>9.1.2. мэдээллийн эх сурвалжийг задруулах нь бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил, албан тушаалын байдал, орлогод хохирол учруулж болзошгүй бол;</p> <p>9.2. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь энэ хуулийн 9.1-д заасан үндэслэлээр нэрээ нууцлахыг хүссэн мэдээлэгчийн нэр, хаяг, эрхэлж буй ажил, мэргэжил, гэр бүлийн байдал, уулзсан байр, хугацаа, захидал, төлбөрийн нэхэмжлэл болон бусад холбогдох мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.</p> <p>9.3. Мэдээллийн нууц эх сурвалж зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтлэл, нэвтрүүлгийн зохиогчоос мэдээллийн эх сурвалжаа илчлэх, мэдээлэл олж авсан арга, хэлбэрээ тайлбарлахыг шаардах, мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзсантай холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх, хариуцлага хүлээлгэхийг хориглоно.</p>

	<p>бол.</p> <p>8.3. Энэ хуулийн 8.2-т зааснаас бусад тохиолдолд мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг тулган шаардах, илчлэхээс татгалзсантай холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, хариуцлага хүлээлгэхийг хориглоно.</p> <p>9 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагад тавих шаардлага</p> <p>9.1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 9.3-т зааснаас бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлж байгаа мэдээ, мэдээллээс үүсэх хариуцлагыг өөрөө хүлээнэ.</p> <p>9.2. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакци нь өөрийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрийг хараат бусаар, бие даан тодорхойлно.</p> <p>9.3. Зар сурталчилгааны болон захиалгат нийтлэл, нэвтрүүлэгтэй холбогдон үүсэх хариуцлагыг захиалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүлээнэ. Хэвлэл мэдээллийн байгууллага нь захиалгат нийтлэл, нэвтрүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа тохиолдолд захиалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг заавал мэдээлнэ.</p> <p>9.4. Хэвлэл мэдээллийн байгууллага нь бодит байдлыг гажуудуулсан буюу бусдыг төөрөгдүүлсэн, эсхүл худал, бодит бус мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно.</p> <p>9.5. Энэ хуулийн 13.1.1-д заасан ёс зүйн дүрэм, хэм хэмжээг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлч нар мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.</p> <p>9.6. Хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчийн нэр, албан тушаал, эрхэлж байгаа ажил, хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээний талаархи мэдээллийг жил бүр, өөрчлөлт орсон тохиолдол бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх үүрэгтэй.</p> <p>10 дугаар зүйл. Мэдээ, мэдээллийн агуулгад хяналт тавихыг хориглох</p>	
--	--	--

	<p>10.1. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах мэдээ, мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.²</p> <p>10.2. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, нэвтрүүлэх мэдээ, мэдээллийн агуулгад хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.</p> <p>11 дүгээр зүйл. Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглох</p> <p>11.1. Төрийн байгууллага, албан тушаалтан өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.</p> <p>11.2. Төрийн байгууллага зөвхөн дараах зорилгоор хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлж болно:</p> <p>11.2.1.хууль тогтоомж болон төрийн байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам зэрэг шийдвэрийг нийтэд таниулах, мэдээлэх;</p> <p>11.2.2.иргэд, аж ахуйн нэгжийн санал, хүсэлтийг хүлээн авах, тэдгээрт тайлбар, хариу өгөх.</p> <p>11.3. Монгол Улсыг дэлхий дахинд сурталчлах, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн байдал, гадаад бодлогын талаархи мэдээ, мэдээллийг хилийн чанадад түгээх чиг үүрэг бүхий мэдээллийн хэрэгсэлтэй байж болно. Үүнтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.</p>	
	<p><u>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ</u> <u>Хэвлэл мэдээллийн зөвлөл</u></p> <p>12 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн зөвлөл</p> <p>12.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус, мэргэшсэн үйл ажиллагааг дэмжих, олон нийтийн хяналт, төлөөллийг хэрэгжүүлэх, хэвлэл мэдээллийн салбарын өөрийгөө хянах, зохицуулах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийг байгуулна.</p> <p>12.2. Зөвлөл нь үйл ажиллагаагаа шударга, ил тод, бие даасан, хараат бус зарчмын үндсэн дээр явуулна.</p> <p>12.3. Зөвлөл нь Монгол Улсын хэмжээнд нэг байна.</p> <p>12.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хэвлэл мэдээллийн</p>	<p><u>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ</u> <u>Хэвлэл мэдээллийн байгууллагын ил тод байдал, хариуцлага</u></p> <p>10 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын ил тод байдал</p> <p>10.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн эзэмшиж буй хувь хэмжээний талаарх мэдээллийг жил бүр, өөрчлөлт орсон тохиолдол бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр, эсхүл цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.</p> <p>10.2. Хэвлэл мэдээллийн байгууллага иргэн, хуулийн этгээдийн захиалгаар төлбөртэй нийтлэл, нэвтрүүлэг түгээх бол ялгах тэмдэглэгээ хэрэглэнэ.</p>

² Одоогийн хуульд - “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”.

	<p>байгууллагын удирдлага, үүсгэн байгуулагч нарыг төлөөлсөн 3 гишүүн, сэтгүүлч нарыг төлөөлсөн 5 гишүүн, иргэдийг төлөөлсөн 3 гишүүн багтана.</p> <p>12.5. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.</p> <p>12.6. Зөвлөлийн гишүүнд улс төрийн намын гишүүнийг нэр дэвшүүлэхгүй.</p> <p>12.7. Ял шийтгэлгүй, иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч Зөвлөлийн гишүүнээр томилно.</p> <p>12.8. Зөвлөлийн бүрэлдэхүүнд орох хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, үүсгэн байгуулагч нарыг төлөөлсөн 3, сэтгүүлч нарыг төлөөлсөн 5 гишүүнд сэтгүүлчийн эрх ашиг, хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, иргэдийг төлөөлсөн 3 гишүүнд хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тус тус нэр дэвшүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгоно.</p> <p>12.9. Зөвлөлийн гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшсэн болон улс төрийн албан тушаалд томилогдсон тохиолдолд түүнийг Зөвлөлийн гишүүнээс чөлөөлнө.</p> <p>12.10. Зөвлөлийн даргыг тус зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн нууц санал хураалтаар нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.</p> <p style="text-align: center;">13 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх</p> <p>13.1. Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>13.1.1. хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, хэм хэмжээг батлах;</p> <p>13.1.2. хэвлэл мэдээллийн байгууллага болон түүний редакци, сэтгүүлч нарын мэргэжлийн үйл ажиллагааны талаар гаргасан гомдлыг хүлээн авах, хянан хэлэлцэх, эвлэрүүлэх, дүгнэлт гаргах;</p> <p>13.1.3. хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>13.1.4. хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах асуудлаар холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд санал оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>13.1.5. Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн байгууллага болон хэрэгсэл, тэдгээрийн үйл ажиллагааны талаархи статистик тоо баримт, судалгааг эрхлэн гаргах;</p>	<p style="text-align: center;">11 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын хүлээх хариуцлага</p> <p>11.1. Хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн ёс зүйн дүрэм, хэм хэмжээг баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.</p> <p>11.2. Зар сурталчилгаа болон сонгуулийн сурталчилгаанаас бусад өөрийн түгээсэн мэдээлэлтэй холбогдон үүссэн хариуцлагыг хэвлэл мэдээллийн байгууллага хүлээнэ.</p> <p>11.3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээс бусад арга хэрэгслээр түгээсэн мэдээлэлтэй холбогдон үүссэн хариуцлагыг зохиогч хүлээнэ.</p> <p style="text-align: center;">12 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл</p> <p>12.1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь Үндсэн хуульт байгууламжийг хууль бусаар өөрчлөх, хүчирхийлэл, садар самуун болон бусад гэмт хэргийг сурталчлах, олон нийтийг уриалах, оюуны өмчийн эрхийг зөрчих, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг задруулах, хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг санаатайгаар гутаах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.</p> <p>12.2. Хэвлэл мэдээллийн байгууллага нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг санаатайгаар гутаан доромжилсон болон бусад хууль бус мэдээллийг сэтгэгдэл болон бусад хэлбэрээр дамжуулан нийтлэх, нэвтрүүлэх боломжийг гуравдагч этгээдэд олгохыг хориглоно.</p> <p>12.3. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээний хөтөлбөрийн мэдээг захиалгаар нэвтрүүлэх, санхүүжүүлэхийг хориглоно.</p> <p>12.4. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч аливаа этгээдийг өөртэй нь хамааралтай мэдээллийг нийтэлж, нэвтрүүлэхээр дарамтлах, нийтэлж, нийтлээгүйн төлөө төлбөр, шан харамж авах, авах оролдлого хийхийг хориглоно.</p> <p style="text-align: center;">13 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээд гомдол гаргах</p> <p>13.1. Иргэн, хуулийн этгээд хэвлэл мэдээллийн байгууллага, түүний сэтгүүлч, хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг тухайн хэвлэл мэдээллийн байгууллагад эсхүл энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан Хэвлэл мэдээллийн зөвлөлд гаргаж болно.</p>
--	--	---

	<p>13.1.6.хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах баталгааг бий болгох, хэрэгжүүлэх, боловсронгуй болгох асуудлаар иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаас тавьж байгаа санал, санаачлагыг дэмжин хамтран ажиллах.</p> <p>13.2. Энэ хуулийн 13.1.2-т заасан гомдлыг хянан шийдвэрлэх журам болон үйлчилгээний хөлсний хэмжээг Зөвлөл батална.</p> <p>14 дүгээр зүйл. Зөвлөлийн ажлын алба</p> <p>14.1. Зөвлөл нь ажлын албатай байна.</p> <p>14.2. Ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, дүрмийг Зөвлөлийн дарга батална.</p> <p>15 дугаар зүйл. Зөвлөлийн санхүүжилт</p> <p>15.1. Зөвлөлийн үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.</p> <p>15.1.1.хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдийн хандив; 15.1.2.олон улсын байгууллагын хандив; 15.1.3.гомдол, маргааныг хянан шийдвэрлэсэн үйлчилгээний хөлс; 15.1.4.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.</p> <p>15.2. Төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх буюу аливаа хэлбэрээр хандив өгөхийг хориглоно.</p>	<p>13.2. Энэ хуулийн 13.1-д заасны дагуу гомдол гаргасан нь иргэн, хуулийн этгээдийн шүүхэд хандах эрхийг хязгаарлахгүй.</p> <p>13.3. Иргэн алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл шүүхэд хандахдаа Иргэний хуулийн 21.2-т зааснаар нотлох үүргийг өөрөө хүлээнэ.</p> <p>14 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллага гомдлыг хянан шийдвэрлэх</p> <p>14.1. Энэ хуулийн 13.1-д заасны дагуу гаргасан гомдлыг хэвлэл мэдээллийн байгууллага, өөрийн байгууллагад мөрдөж буй зохих дүрэм, журмын дагуу хянан шийдвэрлэнэ.</p> <p>14.2. Хэвлэл мэдээллийн байгууллага гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл залруулга, уучлал нийтлэх, эвлэрүүлэх болон бусад хэлбэрээр гомдлыг барагдуулна.</p> <p>14.3. Хэвлэл мэдээллийн байгууллага ирүүлсэн гомдлыг Хэвлэл мэдээллийн зөвлөлд шилжүүлж болно.</p> <p>15 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн зөвлөл</p> <p>15.1. Хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдлыг хангах, түүний үйл ажиллагаатай холбогдсон өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Хэвлэл мэдээллийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-тэй байна. Зөвлөл нь үндэсний хэмжээнд нэг байна.</p> <p>15.2. Зөвлөлийг нийт сэтгүүлчдийн хурлаар байгуулна.</p> <p>15.3. Зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, олон нийтийн төлөөллөөс бүрдэнэ.</p> <p>15.4. Зөвлөлийн гишүүнийг сонгохдоо төрийн байгууллага улс төрөөс хараат бус байдал, мэргэжил, туршлага, ёс зүй, нэр хүндийг нь харгалзан үзнэ.</p> <p>15.5. Зөвлөлийн гишүүдийг сонгох үйл явц нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.</p> <p>15.6. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь гишүүдийн хурал байна.</p> <p>15.7. Зөвлөлийн дүрэм, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох журам, хурлын дэг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам, санхүүжилтийн журмыг Зөвлөлийн</p>
--	---	--

хурлаар хэлэлцэн батална.

16 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх

16.1. Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1. хэвлэл мэдээллийн салбарт мөрдөх нийтлэг ёс зүйн дүрэм, хэм хэмжээг тогтоох;

16.1.2. энэ хуулийн 13.1-д заасны дагуу хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гарсан гомдлыг хянан хэлэлцэх, дүгнэлт гаргах, эвлэрүүлэх;

16.1.3. хэвлэл мэдээллийн байгууллагад залруулга, уучлал нийтлэх болон бусад хэлбэрээр гомдлыг барагдуулах үүрэг хүлээлгэх.

17 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх

17.1. Иргэн, хуулийн этгээд нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн зүгээс нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, худал мэдээлэл нийтэлсэн гэж үзвэл Зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

17.2. Зөвлөл энэ хуулийн 17.1-д заасан гомдлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл хугацааг 30 хоногоор сунгаж болно.

17.3. Зөвлөлийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдол гаргагч шүүхэд хандах эрхтэй.

17.4. Энэ хуулийн 17.3-т зааснаар гомдол гаргагч шүүхэд хандвал Зөвлөл тухайн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг төлөөлөн оролцоно.

18 дугаар зүйл. Зөвлөлийн санхүүжилт

18.1. Зөвлөлийн үйл ажиллагаа дараах эх үүсвэрээс санхүүжинэ:

18.1.1. хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж;

18.1.2. олон улсын байгууллагын хандив, төсөл хөтөлбөрийн санхүүжилт;

18.1.3. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

18.2. Зөвлөл нь төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, улс төрийн нам, сонирхлын зөрчилтэй гэж үзсэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдээс хандив, тусламж авахыг хориглоно.

	<p style="text-align: center;">ТАВДУГААР БҮЛЭГ <u>Бусад зүйл</u></p> <p style="text-align: center;">16 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>16.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p style="text-align: center;">17 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох</p> <p>17.1. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p style="text-align: center;">ТАВДУГААР БҮЛЭГ <u>Бусад зүйл</u></p> <p style="text-align: center;">19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага</p> <p>19.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дараах шийтгэл ногдуулна:</p> <p>19.1.1.энэ хуулийн 4.2, 5.2, 5.3, 5.6, 6.1, 9.3 дугаар зүйлийг зөрчсөн бол зөрчил гаргасан албан тушаалтанд гурван зуун мянгаас нэг сая хүртэл төгрөгийн торгууль ногдуулна;</p> <p>19.1.2.энэ хуулийн 19.1.1 дүгээр заалтыг албан тушаалтан удаа дараа эсхүл ноцтойгоор зөрчсөн бол хэвлэл мэдээллийн байгууллага эсхүл Зөвлөлийн гомдлоор албан тушаалаас халах үндэслэл болно;</p> <p>19.1.3.энэ хуулийн 8.2, 8.4 дүгээр зүйлийг зөрчсөн бол зөрчил гаргасан иргэнд гурван зуун мянгаас нэг сая хүртэл төгрөгийн, хуулийн этгээдэд нэг саяас гурван сая хүртэл төгрөгийн торгууль ногдуулна;</p> <p>19.1.4.энэ хуулийн 10.1, 10.2, 12.1, 12.2, 12.3, 12.4-т заасан заалтыг зөрчсөн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал хэвлэл мэдээллийн байгууллагыг нэг саяас гурван сая хүртэл төгрөгийн торгууль ногдуулна.</p> <p style="text-align: center;">20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох</p> <p>20.1. Энэ хуулийг оны ... дугаар сарын-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>
--	--	---

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСЛҮҮДИЙГ
ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ**

ОДОО ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БАЙГАА	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
---	<p style="text-align: center;">ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ</p> <p style="text-align: center;">1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:</p> <p>1/ 51 дүгээр зүйл:</p> <p style="text-align: center;">“51 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний</p>	---

	<p style="text-align: center;"><u>ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИХ</u></p> <p><u>1. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан тушаал, шийдвэр гаргасан төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг 250000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 60000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.</u></p> <p><u>2. Хуулиар олгогдсон бүрэн эрхээсээ гадуур аливаа хэлбэрээр хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон, нөлөөлсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг 200000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 60000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.</u></p> <p><u>3. Хуульд зааснаас бусад үндэслэлээр мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг тулган шаардах, илчлэхээс татгалзсантай холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, шийтгэл хүлээлгэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан иргэн, албан тушаалтныг 50000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.</u></p> <p><u>4. Хэвлэл мэдээллийн байгууллага нь бодит байдлыг гажуудуулсан буюу бусдыг төөрөгдүүлсэн, эсхүл худал, бодит бус мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.</u></p> <p><u>5. Өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулсан бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан төрийн байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 50000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.</u></p> <p><u>6. Хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээний талаар жил бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлээгүй бол 250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.”</u></p> <p>2 дугаар зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “48” гэсний дараа “51” гэж нэмсүгэй.</p> <p>3 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох</p> <p>3.1. Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	
<p style="text-align: center;">ЭРҮҮГИЙН ХУУЛЬ</p> <p style="text-align: center;">111 дүгээр зүйл. Гүтгэх</p> <p>111.1. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин</p>	- - -	<p style="text-align: center;">МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ</p> <p style="text-align: center;">1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>1/111 дүгээр зүйл:</p>

<p>нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>111.2. Гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>140 дугаар зүйл. Доромжлох</p> <p>140.1. Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p>		<p>“111.1. “Хүний нэр төрийг гутаах зорилгоор илт худал мэдээлэл олон нийтэд тарааснаас хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.”;</p> <p>111.2. Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ял шийтгэнэ.”</p> <p>2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.</p> <p>3 дугаар зүйл. Энэ хуулийг оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>
<p>ИРГЭНИЙ ХУУЛЬ</p> <p>21 дүгээр зүйл. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах</p> <p>21.2. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.</p> <p>511 дүгээр зүйл. Эдийн бус гэм хорыг арилгах</p> <p>511.2. Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.</p>	<p style="text-align: center;">- - -</p>	<p>МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “няцаах үүрэг хүлээнэ” гэсний дараа “<u>Иргэн алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл нотлох үүргийг өөрөө хүлээнэ</u>” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.</p> <p>2 дугаар зүйл. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2 хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>1/511 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:</p> <p>“Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бусад” гэснийг “<u>уучлалт хүсэх, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг нийтэд мэдээлэх зэрэг</u>” гэж өөрчлөн найруулсугай.</p> <p>3 дугаар зүйл. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг” гэснийг хассугай.”</p> <p>4 дүгээр зүйл. Энэ хуулийг оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>
<p style="text-align: center;">- - -</p>	<p style="text-align: center;">- - -</p>	<p style="text-align: center;"><u>ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ</u></p>

		<p><u>ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ</u></p> <p><u>1 дүгээр зүйл.</u> Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд буй хэвлэл мэдээллийн байгууллагыг 2012 оны 12 дугаар сарын 30-ны дотор татан буулгана.</p> <p><u>2 дугаар зүйл.</u> Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>
- - -	<p>ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ</p> <p>1 дүгээр зүйл. 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.</p> <p>2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p>ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ</p> <p>1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлаас 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийг хүчингүй болсонд тооцсугай.</p> <p>2 дугаар зүйл. Энэ хуулийг “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>

ХАРЬЦУУЛАЛТ ХИЙСЭН:

АЖЛЫН АЛБАНЫ ХУУЛИЙН ХЭСГИЙН РЕФЕРЕНТ

Б.ГАНХӨЛӨГ